

ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2026 оны хагас жил

I. ТАЙЛАНГИЙН ЗОРИЛГО

Энэхүү тайлан нь байгууллагын хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт хөгжил, нийгмийн баталгаа болон холбогдох бодлогын хэрэгжилтийн явцыг нэгтгэн дүгнэх зорилготой.

II. ХҮНИЙ НӨӨЦИЙН БҮРДҮҮЛЭЛТ, СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

1. Нийт 11 удаагийн сул орон тооны зар цахим болон дотоод сувгаар нийтэд мэдээлсэн.
2. 73 иргэнтэй ажлын байрны сонгон шалгаруулалтын ярилцлага хийсэн.
3. Үүнээс 39 иргэн ажилд тэнцэж, хөдөлмөрийн гэрээ байгуулсан.
4. Монгол Улсын Засгийн газрын 238 дугаар тогтоол болон байгууллагын даргын тушаалын дагуу 39 албан хаагчийн хөдөлмөрийн гэрээг шинэчлэн баталгаажуулсан.
5. Ажилтнуудын ээлжийн амралтын хуваарийг хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн баталсан.

III. СУРГАЛТ, ХӨГЖИЛ

1. Нийт 14 удаагийн сургалт, хөгжлийн арга хэмжээг зохион байгуулсан.
2. Сургалтад давхардсан тоогоор 104 албан хаагч хамрагдсан.
3. Сургалтыг төрийн байгууллага болон мэргэжлийн ТББ-уудтай хамтран зохион байгуулсан.
4. Гол чиглэлүүд: төрийн цахим үйлчилгээ, архив бичиг хэрэг, худалдан авах ажиллагаа, хиймэл оюун ухааны хэрэглээ, мэргэжлийн ур чадварын хөгжүүлэлт.
5. Албан хаагчид бакалавр болон магистрын түвшний боловсролын сургалтад хамрагдаж байна.

IV. НИЙГМИЙН БАТАЛГАА, АЖИЛТНЫ ДЭМЖЛЭГ

1. 2 албан хаагчийг орон сууц болон газрын дэмжлэгт хамруулсан.
2. 21 ажилтныг Төрийн ордны үйл ажиллагаатай танилцуулсан.
3. 3 ахмад ажилтныг төрийн дээд шагналд тодорхойлж, шагнал гардуулахад дэмжлэг үзүүлсэн.
4. Тэтгэвэрт гарсан ахмадуудад хүндэтгэлийн дэмжлэг олгосон.

5. 14 албан хаагчид хөдөлмөрийн дотоод журмын дагуу цалинтай дэмжлэг олгосон.
6. Судалгаагаар ажилтнуудын 60% нь орон сууцны урьдчилгаанд хамрагдах, 70% нь газар эзэмших, 10% нь өөрийн гэртэй болох зорилготой байна.

V. ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН АРГА ХЭМЖЭЭ

1. Албан хаагчдыг 5 хоногийн урьдчилан сэргийлэх эмчилгээ, эрүүл мэндийн хөтөлбөрт хамруулах төлөвлөгөө боловсруулсан.
2. Үйлчлүүлэгч иргэдэд чиглэсэн шинэ жил, сар шинийн баяр, спорт болон олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээг зохион байгуулсан.

VI. БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх шатанд байна.
2. Нийгмийн баталгааны хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж байна.

VII. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Байгууллагын хүний нөөцийн бодлого нь бүрдүүлэлт, сургалт хөгжил, нийгмийн баталгаа, эрүүл мэндийн дэмжлэг болон бодлогын шинэчлэлийн хүрээнд цогц байдлаар хэрэгжиж, байгууллагын тогтвортой хөгжлийг хангахад чиглэж байна.

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ АВАХ

Захиргаа, хүний нөөцийн удирдлагын албаны дарга : Л.Жаргалсайхан

Утас: 88714554